

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/02/НА-СА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Аудитор: **З.Мөнгөнцэцэг**

Утас: **9937-2208**

Цахим хаяг: [Munguntsetseg@audit.gov.mn](mailto:Munguntsetseg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРӨНН АУДИТЫН ГАЗАР

40008 Дархан-Уул аймгийн  
Дархан сум, 14-р баг  
Утас 7017-3000, Факс 7017-3000  
E-mail darhanuul@audit.gov.mn

2021.12.25 № 252

Тайлбар: -ны 25

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН  
ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.ЛХАМСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ТЭЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ТЭЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид асах талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа болсон материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР/



009020345

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн гол үзүүлэлтүүд

|                                                |                                                   | /сая төгрөгөөр/ |                 |
|------------------------------------------------|---------------------------------------------------|-----------------|-----------------|
|                                                | Үзүүлэлт                                          | 2020.12.31      | 2021.12.31      |
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                 |                 |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 1,124.5         | 2,191.0         |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 19,355.4        | 19,323.7        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>20,479.9</b> | <b>21,514.7</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | 21.6            | 315.7           |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 20,458.3        | 21,199.0        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>20,479.9</b> | <b>21,514.7</b> |
|                                                |                                                   |                 |                 |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 8,611.9         | 9,268.3         |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 7,043.1         | 7,899.3         |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>1,568.8</b>  | <b>1,368.9</b>  |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | 338.3           | 628.3           |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>1,230.6</b>  | <b>740.6</b>    |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                 |                 |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 760.2           | 2,005.9         |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 1,230.6         | 740.6           |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>1,990.8</b>  | <b>2,746.5</b>  |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                 |                 |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 6,878.0         | 7,831.2         |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 6,235.3         | 6,722.5         |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>642.7</b>    | <b>1,108.7</b>  |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>(421.1)</b>  | <b>(805.2)</b>  |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>(132.8)</b>  | <b>(136.0)</b>  |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>88.8</b>     | <b>167.4</b>    |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 110.9           | 199.8           |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 199.8           | 367.2           |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>             |                                                   | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл       |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>6,799.0</b>  | <b>6,508.5</b>  |
|                                                | Урсгал зардал                                     | 6,027.2         | 5,776.8         |
|                                                | Хөрөнгийн зардал                                  | 608.1           | 595.6           |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>6,799.0</b>  | <b>6,546.1</b>  |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           | 4,562.0         | 4,540.0         |
|                                                | Орон нутгийн төсвөөс санхүүжих                    | 1,886.6         | 1,759.9         |
|                                                | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих              | 82.9            | 68.8            |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             | 267.5           | 177.4           |

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Шарын гол сум нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

### **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн ерөнхийлөн захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Дөрөв. Аудитын гол асуудал**

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны тухай хуульд төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна хяналт тавьж ажиллахаар заасан.

Шарын гол сумын орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) хуудсанд шаардлагатай мэдээллийг тавьж ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шарын гол сумын ТЕЗ нь өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй, цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг 1,4,9 дүгээр сар, 3 дугаар улиралд, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг 1-12 дугаар сар, бүтэн жилээр, нийт 17 мэдээллийг хугацаа хоцроосонд албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

### **Долоо. Аудитын илрүүлэлт**

Шарын гол сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 846,479.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15.0 хувь буюу 126,910.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.5 хувь буюу

4,500.9 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 28.8 хувь буюу 243,475.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 55.8 хувь буюу 471,592.7 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

### Зөвлөмж

2022 оны сумын орлогын төсөвт малын тоо толгойн албан татварын орлогын хэмжээг 61,553.0 мянган төгрөгөөр төлөвлөн баталсан боловч орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болон зарцуулалтад төлөвлөөгүй байна. Иймд Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8, ОНХСангийн журмын 4.5,4.6 дахь заалтуудыг мөрдөж ажиллах

### 7.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 3 | ЗГТС                        |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 4 | ТТЗ                         | 15                       | 13                          | 2                  |                 | 13                      |                |       |                            |
| 5 | ТЕЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>15</b>                | <b>13</b>                   | <b>2</b>           |                 | <b>13</b>               |                |       |                            |

### 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн |              | Үүнээс    |              |               |            |                 |              |           |              |
|---|-----------------------------|----------------------|--------------|-----------|--------------|---------------|------------|-----------------|--------------|-----------|--------------|
|   |                             |                      |              | Залруулга |              | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |              | Зөвлөмж   |              |
|   |                             | Тоо                  | Дүн          | Тоо       | Дүн          | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн          | Тоо       | Дүн          |
| A | 1                           | 2                    | 3            | 4         | 5            | 6             | 7          | 8               | 9            | 10        | 11           |
| 1 | ТШЗ                         |                      |              |           |              |               |            |                 |              |           |              |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                      |              |           |              |               |            |                 |              |           |              |
| 3 | ЗГТС                        |                      |              |           |              |               |            |                 |              |           |              |
| 4 | ТТЗ                         | 51                   | 846.5        | 21        | 126.9        | 9             | 4.5        | 6               | 243.5        | 15        | 471.6        |
| 5 | ТЕЗ                         |                      |              |           |              |               |            |                 |              |           |              |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>51</b>            | <b>846.5</b> | <b>21</b> | <b>126.9</b> | <b>9</b>      | <b>4.5</b> | <b>6</b>        | <b>243.5</b> | <b>15</b> | <b>471.6</b> |

/сая төгрөгөөр/

